



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.1 дэх заалт Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 116 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах тухай” А/88 дугаар захирамж, 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын зэрэгт шилжүүлэх тухай А/275 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийг 2019 оны 04 дүгээр сарын 24, 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулахтай холбогдуулан хавсралтад дурдсан байгууллагуудыг 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд албаны бэлтгэл бэлэн байдлыг хангаж, албан хаагчдын амралт чөлөөг хязгаарла, шаардлагатай тохиолдолд ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж идэвх санаачилгатай ажиллахыг дарга, захирал, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

Баянгол дүүргийн Засаг даргын
2019 оны 04 дугаар сарын 10 өдрийн
А/206 дугаар захирамжийн хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ “ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН” ЗЭРЭГТ
ШИЛЖИХ ХЭЛТЭС АЛБА, АЖ АХУЙ, НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

д/д	Хэлтэс албад	Тайлбар
1	Засаг даргын Тамгын газар	
2	Онцгой байдлын хэлтэс	
3	Цагдаагийн 1 дүгээр хэлтэс	
4	Цагдаагийн 2 дугаар хэлтэс	
5	Замын цагдаагийн хэлтэс	
6	Газрын алба	
7	Хөдөлмөр, нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	
8	Мэргэжлийн хяналтын хэлтэс	
9	Эрүүл мэндийн төв	
10	Улаан загалмайн хороо	
11	Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ	
12	Статистикийн хэлтэс	
13	Улсын бүтгэлийн хэлтэс	
14	УБЦТСХКБаянгол Хэрэглэгчдэд үйлчлэх төв	
15	ОСНААУГ-ын Баруун түгээх төв	
16	ОСНААУГ-ын Төв түгээх төв	
17	23 хороо	